

**БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хишиг-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын ХУРААНГУЙ тайлан

Аудитын код: БУА-2026/12/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Булган аймаг
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Д.Батцогт
Утас: 70342580 Цахим хаяг: Battsogtd@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342495 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Аудитор: Б.Энхтөр
Утас: 70342495 Цахим хаяг: enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант, 5-р баг, Булган сум, Булган аймаг,
63082, Утас/Факс:7034-2580
Цахим шуудан:bulgan@audit.gov.mn

2026.03.17 № 328

танай _____ ны № _____ т

ХИШИГ-ӨНДӨР СУМЫН
ЗАСАГ ДАРГА О.БУЯНБАДРАХ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хишиг-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хишиг-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Хишиг-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2025 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,112.5 сая төгрөг, татварын болон татварын бус орлогоор 1,314.4 сая, нийт зарлагыг 2,817.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж, орон нутгийн төсвөөс 1,414.5 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн.

Төсвийн төслийн саналыг 3,112.5 сая төгрөгөөр өгсөн боловч тус саналаас зардлыг 123.0 сая төгрөгөөр бууруулж 2,989.5 сая төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсвийн төслийг үндэслэлтэй төлөвлөсөн боловч ЗДТГ-н үйл ажиллагааны зардал болон тогтмол зардлыг бууруулж баталсан байна.

Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй төлөвлөсөн боловч орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт өссөн, засгийн газрын тогтоолоор цалин нэмэгдсэн, оны эхний үлдэгдлийг нэмж баталсан шалтгаалаан нэмэгдсэн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант

6326050504

үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

АДБОУС 2706. 10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүссэн тухай, санхүүгийн тайлангийн аудит, аудитын тайлантай холбоотой аудиторын хүлээх үүрэг хариуцлагын тухай дэлгэрэнгүй тайлбар өгөхөөр хууль тогтоомжоор шаардсан мэдээллийг тусгана.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.БАТЦОГТ

Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

	/мянган төгрөгөөр/	
Үзүүлэлт	2024.12.31	2025.12.31
Санхүүгийн байдлын тайлан		
Эргэлтийн хөрөнгийн дүн	1,054,276.85	847,935.07
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,395,496.26	2,402,947.14
Нийт хөрөнгийн дүн	3,449,773.11	3,250,882.21
Нийт өр төлбөрийн дүн	36.00	38,915.51
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,449,737.11	3,211,966.70
Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,449,773.11	3,250,882.21
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
Үйл ажиллагааны орлогын дүн	4,944,327.34	4,674,154.94
Үйл ажиллагааны зардлын дүн	3,991,535.99	4,665,653.46
Үйл ажиллагааны үр дүн	952,791.34	8,501.49
Үйл ажиллагааны бус үр дүн	(396,053.82)	(241,871.90)
Үйл ажиллагааны нийт үр дүн	556,737.52	(233,370.41)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,891,809.58	3,445,337.11
Тайлант оны үр дүн	0	(233,370.41)
Эцсийн үлдэгдэл	3,449,737.11	3,211,966.70
Мөнгөн гүйлгээний тайлан		
Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	4,395,586.59	4,469,325.57
Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,808,400.30	4,152,507.20
Үйл ажиллагааны ЦМГ	587,186.29	316,818.37
Хөрөнгө оруулалтын ЦМГ	(438,858.00)	(334,078.27)
Санхүүгийн ажиллагааны ЦМГ	(442.00)	(130,867.32)
Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	429,839.85	577,726.15
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	577,726.15	429,598.93
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,803,506.30	4,444,216.76
Урсгал зардал	2,100,529.80	3,979,271.17
Хөрөнгийн зардал	524,134.30	334,078.27
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		
Улсын төсвөөс санхүүжих	233,134.30	226,543.40
Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	233,134.30	226,543.40

Гурав: Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тус байгууллага “Иргэдийн амар тайван аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлсэн, байгаль орчинд ээлтэй ногоон хөгжлийг цогцлоосон, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, үйлдвэрлэл үйлчилгээг хослуулан хөгжүүлсэн иргэндээ ээлтэй сум болон хөгжинө” гэсэн эрхэм зорилгыг дэвшүүлэн ажиллажээ.

Дөрөв: Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Хишиг-Өндөр сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2025 оны төсвийн төсөлд нийт зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,112.5 сая төгрөг, төсвийн орлогоос 1,314.4 сая, нийт зарлагыг 2,817.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны

төсвийн захирагчид хүргүүлж орон нутгийн төсвөөс 1,414.5 сая төгрөгийн санхүүжилт авахаар төлөвлөсөн.

Төсвийн төслийн саналыг 3,112.5 сая төгрөгөөр өгсөн боловч тус саналаас зардлыг 123.0 сая төгрөгөөр бууруулж 2,989.5 сая төгрөгөөр баталсан байна.

Энэ нь төсвийн төслийг үндэслэлтэй төлөвлөсөн боловч ЗДТГ-н үйл ажиллагааны зардал болон тогтмол зардлыг бууруулж баталсан байна.

Тав. Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Зургаа. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг мөрдөж ажилласан ч хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Долоо. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Албан татварын орлогыг бүрэн төвлөрүүлж ажиллах.

Найм. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 591,243.3 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 36,166.4 мянган төгрөгийн төлбөрийн акт, 554,246.9 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгсөн.

5.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт:

1. Малын тоо толгойн албан татварыг тайлант онд нийт албан татварын 80 хувиар тооцож 104.0 сая төгрөгөөр төлөвлөж баталсан боловч 32.1 сая төгрөгөөр төлөвлөгөө тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.1 дэх заалтыг мөрдөж ажиллаагүй.

2. Түгээмэл тархацтай ашигт малтмалыг 3.0 сая төгрөгөөр төлөвлөж баталсан боловч тайлант онд орлого ороогүй, төлөвлөгөө тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.1 дэх заалтыг мөрдөж ажиллаагүй.

3. Галт зэвсгийн албан татварыг 3980.0 мянган төгрөгөөр тооцож төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 2100.0 мянган төгрөг бол 1880.0 мянган төгрөгийн төлөвлөгөө

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тасарсан нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1, 41.2.1 дэх заалтыг мөрдөж ажиллаагүй.

5.2 Албан шаардлага бичигдээгүй.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Албан татварын орлого бүрдүүлэлттэй холбоотой.

Илрүүлэлт: Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдсэн Ойн менежментийн төлөвлөгөөг "Мөнх ногоон жодоо" ХХК-иар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж 50 хувийг олгосон боловч одоог болтол төлөвлөгөөгөө аваагүй, хүлээлгэж өгөөгүй, гэрээний хугацаа хэтэрсэн.

Өгсөн зөвлөмж:

Ажил гүйцэтгэх гэрээний тусгай нөхцөлийн дагуу алданги тооцох заалтыг мөрлөж ажиллах.

2. Өвс тэжээлийн авлагатай холбоотой:

Илрүүлэлт: Хишиг-Өндөр сумын ЗДТГ-аас 2022 онд 5,049.9 мянган төгрөгийн өвс 5 иргэнд олгосон боловч одоог болтол өвсний төлбөрийг барагдуулаагүй.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтыг мөрдөж ажиллах

3. ЖДҮ-нийн авлагатай холбоотой:

Илрүүлэлт: Жижиг дунд үйлдвэрлэлийн эзэн холбогдогчгүй, нас барсан, Цэнгэл сан, гадаад явсан иргэний хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулаагүй.

Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" авлагыг барагдуулах

4. Шилэн данстай холбоотой:

Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүйгээс 4 мэдээлэл хугацаа хоцроож 1 мэдээлэл огт мэдээлээгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийг 4.1.3 дахь заалтыг мөрдөж ажиллах.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс		Зөвлөмж
				Залруулсан	Залруулаагүй	

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Малын тоо толгойн албан татварыг тайлант онд нийт албан татварын 80 хувиар тооцож 104.0 сая төгрөгөөр төлөвлөж баталсан боловч 32.1 сая төгрөгөөр төлөвлөгөө тасарсан байна.			1	32,116.4									
Түгээмэл тархацтай ашигт малтмалыг 3.0 сая төгрөгөөр төлөвлөж баталсан боловч тайлант онд орлого ороогүй, төлөвлөгөө тасарсан.			1	3,000.0									
Галт зэвсгийн албан татварыг 3980.0 мянган төгрөгөөр тооцож төлөвлөсөн боловч гүйцэтгэлээр 2100.0 мянган төгрөг бол 1880.0 мянган төгрөгийн төлөвлөгөө тасарсан.			1	1,880.0									
Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдсэн Ойн менежментийн төлөвлөгөөг "Мөнх ногоон жодоо" ХХК-иар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулж 50 хувийг олгосон боловч одоог болтол төлөвлөгөөгөө аваагүй, хүлээлгэж өгөөгүй, гэрээний хугацаа хэтэрсэн.							1	2,066.7					
Хишиг-Өндөр сумын ЗДТГ-аас 2022 онд 5,049.9 мянган төгрөгийн өвс 5 иргэнд олгосон боловч одоог болтол өвсний төлбөрийг барагдуулаагүй.							1	5,046.9					
Жижиг дунд үйлдвэрлэлийн эзэн холбогдогчгүй, нас							1	13,533.6					

барсан, Цэнгэл сан, гадаад явсан иргэний хугацаа хэтэрсэн зээлийн авлагыг барагдуулаагүй.												
Дүн			3	36,996.4			3	20,650.3				

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийт дүн												

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтыг мөрдөж ажиллаагүйгээс 4 мэдээлэл хугацаа хоцроож 1 мэдээлэл огт мэдээлээгүй байна.	1	533,596.5					1	533,596.5
Дүн	1	533,596.5					1	533,596.5